



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, АВЛИГЫН ЕРӨНХИЙ
НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

2016 он



Авлигатай тэмцэх газар

**МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ,
АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

АГУУЛГА

НЭГ. МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	5
1.1 АВЛИГЫН ЭСРЭГ ОЛОН НИЙТИЙГ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР	5
1.2 ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭХ, ХАДГАЛАХ, ХЯНАН ШАЛГАХ ЧИГЛЭЛЭЭР	11
1.3 ХУУЛИАР ХАРЬЯАЛУУЛСАН ГЭМТ ХЭРЭГТ ЯВУУЛСАН МӨРДӨН БАЙЦААЛТЫН ЧИГЛЭЛЭЭР	21
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	27
2.1 АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКС.....	27
2.2 ХӨГЖИЖ БУЙ УЛС ОРНУУДААС ГАДАГШ ШИЛЖСЭН ХУУЛЬ БУС САНХҮҮГИЙН УРСГАЛ.....	28
2.3 ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁСНЫ ИНДЕКС	29
2.4 МӨНГӨ УГААХЫН ЭСРЭГ ИНДЕКС	30
2.5 ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ	30
2.6 ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА.....	33

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрэм, аймаг, нийслэлээр.....	7
Хүснэгт 2. Соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт, оноор	8
Хүснэгт 3. Албан тушаалтнуудын ХАСХОМ-ийн бүрдүүлэлт, оноор	11
Хүснэгт 4. Бүрдүүлэлтийн хяналт шалгалт хийсэн ХАСХОМ-ийн тоо, оноор	13
Хүснэгт 5. ХАСУМ-ээ хянуулаагүй томилогдсон зөрчил, тоогоор	14
Хүснэгт 6. Нарийвчилсан хяналт шалгалт хийсэн ХАСХОМ-ийн тоо, оноор.....	14
Хүснэгт 7. Мэдүүлэг гаргагч болон мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудыг чадавхжуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтад оролцогчдын тоо.....	15
Хүснэгт 8. Их хэмжээний өөрчлөлт мэдүүлсэн байдал, оноор.....	18
Хүснэгт 9. Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл тайлбар гаргасан байдал, оноор	18
Хүснэгт 10. Хүлээн авсан авлига, ашиг сонирхлын зөрчил бүхий өргөдөл, гомдол, мэдээлэл	19
Хүснэгт 11. Хянан шийдвэрлэсэн ӨГМ, шийдвэрлэлтээр.....	20
Хүснэгт 12. Авлигын төсөөллийн индексийн утга болон үнэлгээнд хамрагдсан улс орнууд дунд эзлэх байр.....	27
Хүснэгт 13. Хөгжиж буй улс орнуудаас гадагш шилжсэн хууль бус санхүүгийн урсгалын хэмжээ, 2003-2012 онд, сая ам. доллар	29
Хүснэгт 14. Хууль дээдлэх ёсны индексийн дэд үзүүлэлтээр, Монгол Улс	29
Хүснэгт 15. Монгол Улсын Мөнгө угаахын эсрэг индексийн үзүүлэлт, оноор	30
Хүснэгт 16. Төрийн байгууллагын ШБҮ, дэд үзүүлэлтээр.....	31
Хүснэгт 17. Шударга байдлын үнэлгээ-2015, байгууллагаар	32
Хүснэгт 18. Монгол Улсад авлига хамгийн их тархсан институц аль нь вэ?, хувиар...	33

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ, оноор	6
Зураг 2. Олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт болон сургалтад хамрагдсан хүний тоо, аймаг, нийслэлээр	8
Зураг 3. Албан тушаалтнуудын ХАСХОМ-ийн 2015 оны бүрдүүлэлт, ангилал, тоогоор	12
Зураг 4. ХАСХОМ гаргагч, аймгаар	12
Зураг 5. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийн тоо, оноор	16
Зураг 6. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийн шийдвэрлэлт, оноор	16
Зураг 7. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ, аймгаар...	17
Зураг 8. Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл тайлбар гаргасан байдал, аймаг, нийслэлээр	18
Зураг 9. Авлига, ашиг сонирхлын зөрчил бүхий ӨГМ, агуулгаар	19
Зураг 10. Хянан үзсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо оноор.....	21
Зураг 11. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт, оноор.....	22
Зураг 12. Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийн тоо, оноор.....	22
Зураг 13. Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийн шийдвэрлэлт, тоогоор	23
Зураг 14. Эрүүгийн хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдсан нийт хүний тоо, албан тушаалын байдлаар.....	23
Зураг 15. Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо, оноор	24
Зураг 16. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн, битүүмжилсэн хэмжээ, оноор, тэрбум төгрөг.....	24
Зураг 17. Учирсан хохирлын дүнд мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн, битүүмжилсэн хувь, оноор	25
Зураг 18. Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийн хувийн жин, аймаг, нийслэлээр	25
Зураг 19. Мөрдөн байцаалт явуулсан хэргийн шийдвэрлэлт, аймаг, нийслэлээр	26
Зураг 20. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, сая төгрөг	26
Зураг 21. Авлигын төсөөллийн индекс-2015, улсаар	28
Зураг 22. Хүүхдийн шударга байдлын түвшин, оноор.....	34

НЭГ. МОНГОЛ УЛСЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Авлигатай тэмцэх газар нь Монгол Улсад шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянан шалгах талаар цогц арга хэмжээг хэрэгжүүлэн, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн өргөн оролцоотойгоор улсын хэмжээнд зохион байгуулав.

Монгол Улсын Их Хуралд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль, УИХ-ын 2007 оны 07, 2008 оны 13, 2011 оны 55, 2012 оны 55 дугаар тогтоол, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 5, 20 дугаар тогтоолын хэрэгжилт болон авлигын ерөнхий нөхцөл байдлыг мэдээлж байна.

1.1 АВЛИГЫН ЭСРЭГ ОЛОН НИЙТИЙГ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ, АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

1. Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр:

Авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалын дагуу 122 төрийн байгууллагыг хамруулан үнэлгээ хийж, үр дүнг олон нийтэд мэдээлэв.


Шилэн дансны тухай хуулийг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан төрийн байгууллага, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны онцлогт тохируулан Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлалыг шинэчлэн боловсруулж Авлигатай тэмцэх газрын даргын 2015 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн А/88 дугаар тушаалаар батлуулан, түүний дагуу холбогдох үнэлгээг хийж, үр дүнг нь олон нийтэд мэдээлэв.

Энэхүү үнэлгээг хийснээр төрийн байгууллага авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх, хэрэгжилтийг хангуулах, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, санал санаачилгыг дэмжих, үлгэр жишээ, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд, байгууллагын зүгээс уг үйл ажиллагаанд хяналт тавих боломжийг бүрдүүлэх, иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах ач холбогдолтой юм.

Үнэлгээнд Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг болон Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог 7 байгууллага, 15 яам, Засгийн газрын 28 агентлаг (Зэвсэгт хүчний жанжин штаб, Тагнуулын ерөнхий газар үнэлгээнд хамрагдаагүй), бүх аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 39 хуулийн этгээд, Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний 2 байгууллага (Шүүхийн шинжилгээний хүрээлэн, Хууль сахиулахын их сургууль) буюу нийт 122 байгууллагыг хамрууллаа.

Аргачлалын дагуу Төрийн байгууллагын авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн биелэлтийг 0-70 оноо, авлигатай тэмцэх санал, санаачилгыг 0-30 оноо буюу нийт 100 оноогоор үнэлдэг бөгөөд энэ жилийн улсын дундаж үнэлгээ 68.2 хувьтай байгаа нь 2014 оны дүнтэй харьцуулбал 8.2 хувь, 2013 оноос 20.0 хувиар нэмэгдсэн эерэг үзүүлэлттэй байна. Үнэлгээний үр дүнг өмнөх онуудтай харьцуулсан байдлаар (Зураг 1.)-д харуулав.

Зураг 1. Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ, оноор



Үнэлгээний дундаж оноо нэмэгдсэнийг авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, түүний удирдлага анхаардаг болсон болон төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны хүчин чармайлтын үр дүн гэж үнэлгээ хийсэн хөндлөнгийн шинжээчид үзсэн байна. Шинжээчид авлигын эсрэг үйл ажиллагаанд удирдлагын манлайлал чухал гэдгийг тэмдэглэн Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний статистикийн хороо, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Сангийн яам, Мэдээлэл технологи, шуудан харилцаа, холбооны газар, Худалдан авах ажиллагааны газар, Дорноговь, Орхон аймаг, Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар, “Мэдээллийн технологийн үндэсний парк” ТӨҮГ, “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийг сайшаан дүгнэжээ. Харин Төрийн албаны зөвлөл, Гадаад хэргийн яам, Онцгой байдлын ерөнхий газарт анхаарлаа хандуулах шаардлагатайг онцолсон байна.

Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээнд жил дараалан бага оноотой үнэлэгдсэн, оноо нь буурсан байгууллага болон иргэдийн санал гомдол, судалгааны дүнгийн мөрөөр 2015 онд Ховд, Говь-Алтай, Увс, Дорноговь, Булган аймгийн 52 суманд ажиллаж, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, орон нутагт авлигын эсрэг соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулав. Улмаар Сангийн яам, Хүүхдийн төлөө үндэсний газар, Оюуны өмчийн газар, Архивын ерөнхий газар, Мэдээлэл технологи, шуудан, харилцаа холбооны газар, Мал эмнэлэг, үржлийн газар, Хил хамгаалах ерөнхий газар, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, Эрчим хүчний зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, нийслэлийн Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газар, Налайх, Сүхбаатар, Багахангай, Багануур дүүрэг, Барилга хөгжлийн төв, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ судалгаа мэдээллийн төв зэрэг байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллалаа. Томилолтоор ажиллах явцад өөртөө урамшуулал олгох шийдвэр гаргадаг, мэдэгдэл, тайлбараа гаргадаггүй, хууль тогтоомжид заасан мэдээллийн ил тод байдал хангалтгүй зэрэг нийтлэг зөрчил дутагдал илэрсэн болно.

Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрмийг хянаж хүчингүй болгуулах, зөвлөмж хүргүүлэх, өөрчлөх санал боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв. Дүрэм, журмыг хянах, авлига, ашиг сонирхлын зөрчил дутагдлыг арилгуулах ажлын хүрээнд дараахь аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан дүрэм, журмыг хүчингүй болгуулахаар 64 албан бичиг хүргүүлснээс, 33 дүрэм, журмыг хүчингүй болгуулж, 30 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Авлига гарч болох нөхцөл боломж бүрдүүлсэн төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр, журам, дүрэм, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Хүчингүй болгуулах, өөрчлөх санал боловсруулж хүргүүлсэн	Үүнээс:		
		-хүчингүй болгуулсан	-нэмэлт, өөрчлөлт оруулсан	-шийдвэрлэгдээгүй/ шийдвэрлэгдэх шатандаа
Булган	29	7		22
Говь-Алтай	2	2		-
Дорноговь	4	4		-
Увс	12	12		-
Ховд	2	2		-
Улаанбаатар	15	6		9
Дүн	64	33		31

Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр авлигад өртөх нөхцөл байдлын үнэлгээг гааль, цагдаагийн байгууллага, нийгмийн даатгал, эрүүл мэнд, боловсрол, барилгын салбаруудад хийв. Уг үнэлгээ болон Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх 2012, 2014 оны судалгааны дүнгээр бусад төрийн байгууллагуудын дунджаас доогуур үнэлэгдсэн байгууллага, АНУ-ын Азийн сангийн санхүүжилтээр “Хараат Бус Судалгааны Хүрээлэн” ТББ-ын 2014 онд хийсэн “Эрүүл мэндийн салбарын авлигын нөхцөл байдлын судалгаа”-аар авлига, ашиг сонирхлын зөрчилд илүү өртөх эрсдэл өндөртөйд тооцогдсон 2, 3 дугаар шатлалын эмнэлгүүдийн ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр нэг бүрчилсэн арга хэмжээ авч хэрэгжүүллээ. Энэхүү ажлын хүрээнд улсын 3 дугаар шатлалын эмнэлэг Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төв, улсын Нэгдүгээр төв эмнэлэг, хоёрдугаар шатлалын Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газруудын цахим хуудсыг үнэлж байгууллага тус бүрт мэдээллийг ил тод байршуулах чиглэлээр тусгайлан зөвлөмж хүргүүлсэн бөгөөд авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан 3 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулан, холбогдох хууль тогтоомж зөрчсөн 50 гэрээ, эрх хэмжээгээ хэтрүүлж гаргасан 4 журам, хүчингүй болсон шийдвэр үндэслэн баталсан 3 журмыг тус тус хүчингүй болгуулсан байна.

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг үр дүнтэй хангах зорилгоор Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны 196 дугаар тушаалаар баталсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны журам”-д авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг илүү тодорхой болгон тусгасан нь төрийн байгууллага, албан тушаалтанд хуулиар хүлээлгэсэн үүргээ зохих түвшинд биелүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн арга хэмжээ болсон гэж дүгнэж байна.

Илэрсэн нийтлэг зөрчил дутагдлыг дахин гаргуулахгүй байх, албан тушаалтныг авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын хор хөнөөлийг ухуулан таниулах зорилгоор аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус зохицуулах зөвлөл, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, эрүүл мэндийн төвийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн

оролцоотой аж ахуйн нэгжийн захирал, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, Засгийн газрын агентлагийн дарга зэрэг албан тушаалтнуудад 15 удаагийн зөвлөмж хүргүүлсэн байна.

Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах чиглэлээр зарим байгууллагад ажиллав. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээний хүрээнд Гадаад харилцааны яам, Гаалийн ерөнхий газар, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, Ашигт малтмалын газар, Нийслэлийн өмчийн харилцааны газар, Авто тээврийн үндэсний төв, Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв, Баянзүрх дүүргийн Цагдаагийн газар, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар тус газрын мөрдөн байцаагчийн хүргүүлсэн 14 мэдэгдлийн мөрөөр ажиллаж, хэрэгжилтийг хангуулав. Энэ хүрээнд Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын хууль зөрчсөн 5 тушаал, 6 гэрээ, Баянзүрх дүүргийн Өмч, газрын харилцааны албаны даргын 1 тушаалын холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгуулсан бөгөөд зарим байгууллагад арга хэмжээний тусгай төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байна. Мөн Авлигын эсрэг хуульд заасны дагуу 2015 онд 15 салбар, байгууллагын ёс зүйн дүрмийн төсөлд санал өгч, төслийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт хамтран ажиллав.


Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг олон хэлбэрээр зохион байгуулав. Соён гэгээрүүлэх чиглэлээр 2015 онд нийт 263 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 20257 иргэнийг хамруулсан байна (Хүснэгт 2). Өмнөх онтой харьцуулахад зохион байгуулсан сургалтын тоо 26-аар, хамрагдсан хүний тоо 982-оор буурсан дүнтэй байна.

Хүснэгт 2. Соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт, оноор

	2014	2015
Сургалт тоо	289	263
Хамрагдсан хүн	21239	20257

Соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтыг аймаг, нийслэлээр (Зураг 2.)-т харуулав.

Зураг 2. Олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт болон сургалтад хамрагдсан хүний тоо, аймаг, нийслэлээр



Соён гэгээрүүлэх чиглэлээр 2015 оны хувьд дараахь арга хэмжээг тусгайлан авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бага насны хүүхдэд шударга ёсны ойлголт өгөх, хариуцлагыг бий болгох зорилгоор “Туулай хүүгийн адал явдал” гарын авлагыг боловсруулж “Монголын сурагчдын холбоо” ТББ-тай хамтран “Лидер сурагч” академийн шилдэг 40 сурагчийг сургагч багшаар бэлтгэн нийслэлийн 80 ерөнхий боловсролын сургуульд түгээх ажлыг зохион байгуулж байна. Одоогийн байдлаар 40 гаруй сургуулийн 2, 3 дугаар ангийн 1860 сурагчдад тайлбарлан таниулаад байна.

- “Шударга ёс бидний тэмүүлэл” сургалтын гарын авлагыг ерөнхий боловсролын сургуулийн багш, сурган хүмүүжүүлэгч нарт зориулан бэлтгэн гаргав.

- Эрүүл мэндийн салбарт авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Талархлаа зөв илэрхийлье” нэг сарын аяныг өрнүүлж авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, шударга байдал, ёс зүйн асуудлаар сургагч багшаар лекц уншуулж, тус салбарын 1872 ажилтан, албан хаагчдыг хамруулав.

- Цагдаагийн ерөнхий газартай хамтран авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулах сургалт явуулах сургагч багшийн сургалтыг зохион байгуулж 133 цагдаагийн албан хаагчийг хамруулав. Энэ нь орон нутагт авлигын хор хөнөөлийг таниулах, хууль тогтоомжийг сурталчлах ажлын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой болсон.

- Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, авлигатай тэмцэх ажлын талаар мэдээлэл өгөх зорилгоор хувийн хэвшлийнхэнд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран “Бизнес ба хөгжил” сэтгүүлийг хамтран эрхлэн гаргаж, барилга, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудын болон орон нутгийн бизнес эрхлэгчдийн төлөөлөлтэй нүүр тулсан ярилцлага, цуврал хэлэлцүүлэг зохион байгуулав.

- “Өндөр түвшний авлига” түүнд хамаарах дөрвөн дэд сэдвийн асуудлаар судлаачдын дунд цахим хэлэлцүүлэг өрнүүлж, хэлэлцүүлгийн сэдвүүдээр “VIP эксперт” өндөр түвшний авлигаас ангижрах замын зурагт сэтгүүлийг хэвлэн нийтлүүлж, иргэд олон нийтийн хүртээл болголоо.

- Оюутан залуус, шинээр төрийн албанд томилогдсон албан тушаалтнуудад авлигын эсрэг мэдлэг олгох зорилгоор “Шударга ёсны төлөө” хамтдаа сургалтыг 2015 оны 6 дугаар сараас эхлэн сар бүр зохион байгуулж байна.

- Мөн авлигын эсрэг олон улсын өдрийг “Шударга нийгмийг хамтдаа бүтээе” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж, “Шударга ёсны төлөө 2015” сайн засаглалын сайн санаачилгыг 9 номинациар тодруулж, өргөмжлөв. Мөн энэ өдрийг угтан 5 төрлийн тэмцээн, уралдааныг зорилтот бүлэгт хандан зарлаж дүгнэв.

Олон улсын болон төрийн бүс байгууллагуудтай хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэв.

Авлигатай тэмцэх газар, Азийн хөгжлийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран Ази, Номхон далайн орнуудын Авлигын эсрэг санаачилгын 20 дахь удаагийн Удирдах зөвлөлийн уулзалт, 13 дахь удаагийн бүс нутгийн семинарыг 31 орны 80 гаруй төлөөлөгчдийг урьж оролцуулан Улаанбаатар хотноо 2015 оны 11 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зүүн Европ, төв Азийн авлигын эсрэг сүлжээний Стамбулын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний Монгол Улсын үнэлгээг хариуцсан багийн гишүүд манай оронд ажиллаж нийт 10 сэдвийн хүрээнд сэдэв тус бүрийн чиглэлийн 40 гаруй төрийн байгууллага, мэргэжлийн холбоодыг урьж уулзалт зохион байгуулсан байна.

Улсын Их Хурлын Тамгын газрын “Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь” төслийн санхүүжилтээр НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн 2, 5 дугаар бүлгийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээг хийхтэй холбогдуулан үнэлгээ хийхэд ашигладаг олон улсын “Омнибус” програмыг монгол хэлнээ хөрвүүлэн, 23 байгууллагын 28 албан хаагчийг чадавхжуулах сургалтад хамруулсан бөгөөд дээр

дурдсан конвенцийн 2,5 дугаар бүлгийн хэрэгжилтийн тайланг 21 байгууллагаас бичгээр болон цахимаар авч зөвлөх үйлчилгээний багт хүргүүлэн мэдээлэл солилцон хамтран ажиллав.

Авлигын эсрэг үндэсний стратегийн төслийн хэлэлцүүлгийг Ерөнхийлөгчийн Тамгын газар, “Транспэрэнси интернэшнл Монгол” ТББ-тай хамтран зохион байгуулав.

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, “Сонгогчдын боловсрол төв” төрийн бус байгууллагатай хамтран “Сонгуулийн санхүүжилт шинэчлэлийн асуудал” сэдвээр Улсын Их Хурлын гишүүд, улс төрийн нам, төрийн болон иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг хамруулан хэлэлцүүлэг зохион байгуулсан.

“Глоб интернэшнл” ТББ-тай хамтран хүний эрхийн болон ёс зүйн өндөр мэдрэмжтэй, шударга хуульчдыг бэлтгэхэд хувь нэмэр оруулах зорилгоор эрх зүйн чиглэлээр суралцаж буй оюутан залууст Авлигын эсрэг боловсрол олгох “Хангай ба түүний нөхөд юу хэлэв?” кино сургалтын хөтөлбөрийг боловсруулав.

Авлигын шалтгаан, нөхцлийг тогтоох чиглэлээр судалгаа зохион байгуулж, үр дүнг олон нийтэд хүргэж ажиллав.

Авлигын индексийн судалгаа болон Төрийн байгууллагын шударга байдлын судалгааг нэгтгэн, БНСУ-ын Шударга байдлын үнэлгээний аргачлал, арга зүйд тулгуурлан Шударга байдлын үнэлгээний аргачлал, аргазүйг боловсруулж батлуулав.

Уг аргачлал, арга зүйн дагуу 2015 оны Шударга байдлын үнэлгээнд 62 төрийн байгууллагыг хамруулсан ба үнэлгээний хүрээнд тухайн төрийн байгууллагаас төрийн үйлчилгээ авсан 2330 иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, 1390 төрийн албан хаагч, 620 шинжээчээс мэдээлэл цуглуулах ажлыг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлж, үр дүнгийн тооцооллыг хийв (Үнэлгээний үр дүнг Хүснэгт 17.-д харуулав).

Улс төр, шүүх, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөллийн 2014 оны судалгааны үр дүнгийн тооцоолол 3.58 гарсан ба судалгааны тайланг боловсруулан хэвлүүлж, олон нийтэд түгээв. Уг судалгааны үр дүнг парламентад суудалтай намууд болон төрийн захиргааны төв байгууллагууд, хууль сахиулах байгууллагууд, шүүх зэрэг 41 байгууллагын төлөөллийг оролцуулан танилцуулан, хэлэлцүүлээ. Мөн 2015 оны судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2015 оны 12 дугаар сард эхлүүлэв.

Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх 2014 оны судалгааны үр дүнг судалгаанд хамрагдсан байгууллагуудын төлөөлөлд танилцуулах ажлыг зохион байгуулж, судалгааны үр дүнгийн тайланг хэвлүүлэн олон нийтэд түгээн, мэдээлэв. 2014 оны судалгааны дүнг Сангийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн халамж үйлчилгээний төв, Цагдаагийн ерөнхий газар, Замын цагдаа, Хан-Уул, Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улсын нэгдүгээр төв эмнэлэг болон Улсын гуравдугаар төв эмнэлгийн ажилтнуудад танилцуулж хэлэлцүүлэг өрнүүлэв.

“Хүүхдийн шударга байдал-2015” судалгааг цахим хэлбэрээр явуулж байгаатай холбогдуулан судалгааны асуулгыг онлайн судалгааны “SurveyMonkey” программыг ашиглан хамрах хүрээг өргөжүүлэн анх удаа улсын хэмжээнд 21 аймаг, 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 7-11 дүгээр ангийн сурагчдыг хамруулан, судалгааг зохион байгуулан ажиллаж байна.

Цагдаагийн байгууллагын авлига, хүнд суртал болон ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй ажлын байр, албан тушаал, удирдах алба хаагчдын авлигын хандлагыг тодорхойлох судалгааг нийслэлийн 4 дүүрэг, 3 аймгийн цагдаагийн газрын үйл ажиллагааг хамруулан 305 цагдаагийн албан хаагч, 331 иргэнээс асуулга авч зохион байгуулсан бөгөөд дүнг нийслэл, дүүргүүдийн цагдаагийн удирдах албан хаагчдад мөн судалгааны дүнгээр авлигад өртөх эрсдэл өндөртэй гарсан дүүргийн замын цагдаагийн хэрэг бүртгэгч, байцаагч нарт судалгааны дүнг танилцуулах ажлыг зохион байгуулав.

1.2 ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ БҮРТГЭХ, ХАДГАЛАХ, ХЯНАН ШАЛГАХ ЧИГЛЭЛЭЭР

1. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийн бүрдүүлэлт

Улсын хэмжээнд 2014 оны ХАСХОМ-ээ гаргах 38423 мэдүүлэг гаргагч бүртгэгдсэнээс 38422 мэдүүлэг гаргагч буюу 99.99 хувь нь мэдүүлгээ гаргаж, 1 мэдүүлэг гаргагч /МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүн Б.Цэнддоо/ хугацаа хожимдуулсан, 1 мэдүүлэг гаргагч /МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүн Д.Сосорбарам/ мэдүүлгээ гаргаж өгөхөөс татгалзсан дүнтэй байв.


Харин 2015 оны ХАСХОМ-ээ гаргах 39853 мэдүүлэг гаргагч бүртгэгдсэнээс 39850 мэдүүлэг гаргагч буюу 99.99 хувь нь бүртгүүлсэн. Үүнээс хуульд заасан хугацаанд 39848 мэдүүлэг гаргагч бүртгүүлсэн бол 2 мэдүүлэг гаргагч /Санхүүгийн зохицуулах хорооны Захиргаа, хүний нөөцийн газрын дарга А.Ундрах, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Ц.Эрдэнэбаяр/ хугацаа хожимдуулсан, 3 мэдүүлэг гаргагч /Төрийн тусгай хамгаалалтын газрын Харуулын албаны дарга Ж.Самбалхүндэв, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Ч.Дэчингалсан, Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Л.Гэрэлт-Од/ тус тус мэдүүлгээ гаргаагүй байна. Дээрх зөрчил гаргасан албан тушаалтнуудад Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцуулах албан бичгийг холбогдох газруудад хүргүүлж, биелэлтийг ханган ажиллав (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Албан тушаалтнуудын ХАСХОМ-ийн бүрдүүлэлт, оноор

Үзүүлэлт		2011 оны ХАСХОМ	2012 оны ХАСХОМ	2013 оны ХАСХОМ	2014 оны ХАСХОМ	2015 оны ХАСХОМ
Бүрдүүлбэл зохих		45858	47142	51584	38423	39853
Бүрдүүлсэн нийт мэдүүлэг гаргагчийн тоо		45762	47127	51579	38422	39850
Үүнээс:	Хугацаа хожимдуулж мэдүүлсэн	7	22	6	1	2
Мэдүүлгээ гаргаж өгөөгүй		96	15	5	1	3
Бүрдүүлэлтийн хувь		99.79	99.97	99.99	99.99	99.99

ХАСХОМ гаргагчдыг төрийн албаны ангиллаар авч үзвэл төрийн захиргааны албан тушаалтан 12181, төрийн тусгай албан тушаалтан 12047, төрийн улс төрийн албан тушаалтан 7515, төрийн үйлчилгээний албан тушаалтан 4226 байв.

Зураг 3. Албан тушаалтнуудын ХАСХОМ-ийн 2015 оны бүрдүүлэлт, ангилал, тоогоор




Авлигатай тэмцэх газарт 2014 оны ХАСХОМ-ээ мэдүүлбэл зохих 270 мэдүүлэг гаргагчийн 268 нь хуульд заасан хугацаандаа мэдүүлж байсан бол харин 2015 оны ХАСХОМ-ээ мэдүүлбэл зохих 269 албан тушаалтан мэдүүлгээ хуулийн хугацаанд 100 хувь шинэчлэн мэдүүлснийг бүртгэж авсан. Үүнээс 2015 онд 71 албан тушаалтан шинээр томилогдсон бөгөөд 17 албан тушаалтан их хэмжээний өөрчлөлтөө бүртгүүлжээ.

2015 онд ХАСХОМ-ээ шинэчлэн мэдүүлсэн 39850 албан тушаалтнаас 26580 буюу 66.7 хувь нь Улаанбаатар хотод, 13270 буюу 33.3 хувь нь нь орон нутагт байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын Тамгын газарт ХАСХОМ-ээ гаргагч албан тушаалтнуудыг авч үзвэл Хөвсгөл аймагт 991 ХАСХОМ гаргагч, Төв аймагт 933, Завхан аймагт 787, Өвөрхангай аймагт 784, Архангай аймагт 757, Ховд аймагт 742 ХАСХОМ гаргагч байна.

Зураг 4. ХАСХОМ гаргагч, аймгаар



2014-2015 онд мэдүүлэг гаргагчдын тоо буурсан нь Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоолоор “Хувийн ашиг сонирхлын

мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зарим албан тушаалтны жагсаалт"-ыг шинэчлэн баталж, төрийн захиргааны болон улс төрийн, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтнуудаас зарим мэдүүлэг гаргагчийг хассантай холбоотой юм.

2. ХАСХОМ-ийн бүрдүүлэлтийн болон нарийвчилсан хяналт шалгалт

Албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах үйл ажиллагаа нь авлигаас урьдчилан сэргийлэх нэг чухал арга хэрэгсэл юм. Авлигатай тэмцэх газар нь хууль, тогтоомжид заасан чиг үүргийн дагуу **ХАСХОМ-ийн бүрдүүлэлтийн болон ХАСХОМ-ийн нарийвчилсан хяналт шалгалтыг** хийж ажиллалаа.

Бүрдүүлэлтийн хяналт шалгалт (их хэмжээний өөрчлөлтөө, эсхүл шинээр томилогдсон албан тушаалтан 30 хоногийн дотор ХАСХОМ-ээ мэдүүлсэн эсэх)-ын хүрээнд Авлигын эсрэг хууль тогтоомж, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд түгээмэл гарч буй зөрчлийг арилгуулах чиглэлээр төрийн байгууллагуудад дүгнэлт, зөвлөмж хүргүүлэв.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтын чиглэлээр Гадаад хэргийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Аж үйлдвэрийн яам, Хил хамгаалах ерөнхий газар, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, Оюуны өмчийн газар, Хүүхдийн төлөө үндэсний газар, Архивын ерөнхий газар, нийслэлийн 5 дүүрэг /Баянзүрх, Сүхбаатар, Налайх, Багануур, Багахангай/, 12 аймаг /Говь-Алтай, Увс, Булган, Дорноговь, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Сэлэнгэ, Орхон, Хөвсгөл/-ийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх 161 байгууллагуудад ажиллан 2014, 2015 оныг хамруулан шалгалаа.

Бүрдүүлэлтийн хяналт шалгалтын хүрээнд 2015 онд нийт 285 хүнд хуулийн дагуу хариуцлага тооцуулсан бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах талаар зохих арга хэмжээг авч ажилласан (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Бүрдүүлэлтийн хяналт шалгалт хийсэн ХАСХОМ-ийн тоо, оноор

		2013	2014	2015
Шалгагдсан байгууллага		73	76	161
Нийт шалгасан ХАСХОМ		2267	2528	1521
Хариуцлага тооцуулсан:		67	260	285
Үүнээс:	ИТХ-ын Ажлын албаны дэргэдэх ёс зүйн хорооны хурлаар “Анхааруулга”	14	-	129
	АЭХ-ийн 13.8.1-т заасны дагуу “Сануулах”	33	235	136
	АЭХ-ийн 13.8.2-т заасны дагуу “цалингийн хэмжээг бууруулах”	11	20	20
	АЭХ-ийн 13.8.3-т заасны дагуу “албан тушаал бууруулах”	5	-	-
	АЭХ-ийн 13.8.4-т заасны дагуу “огцруулах буюу ажлаас халах”	1	3	-
Хариуцлага тооцогдсон эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ-аас чөлөөлсөн/		3	2	-

Төрийн зарим байгууллагад нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг Авлигатай

тэмцэх газраар хянуулалгүйгээр томилох зөрчил гарсаар байна. Тайлан мэдээнээс харахад мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтаар 2015 онд ХАСУМ-ээ хянуулаагүйгээр 768 этгээд томилогдсон зөрчилтэй байв. Эдгээрээс 634 албан тушаалтныг томилсон шийдвэрийг хүчингүй болгон чөлөөлүүлж, ХАСУМ-ийг хянуулах арга хэмжээ авч ажиллав. Одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжид ХАСУМ-ээ хянуулаагүй томилсон зөрчлөө арилгаагүй, хууль зөрчин томилгоо хийсэн албан тушаалтанд хариуцлага тооцох зохицуулалт байхгүй байна. Цаашид авлигын эсрэг хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт оруулж, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх зайлшгүй шаардлага гарч байна.

Хүснэгт 5. ХАСУМ-ээ хянуулаагүй томилогдсон зөрчил, тоогоор

	2013	2014	2015
Бүрдүүлэлтийн хяналтаар ХАСУМ-ээ хянуулаагүй томилогдсон зөрчилтэй	699	1512	768
Үүнээс: ХАСУМ-ийг хянуулах арга хэмжээ авсан	277	1272	634

Мэдүүлгийн нарийвчилсан хяналт шалгалтаар 2015 онд 552 албан тушаалтны ХАСХОМ-ийг шалгасан бөгөөд хөрөнгө, орлогоо худал мэдүүлсэн бол сахилгын хариуцлага хүлээлгэх, сахилгын хариуцлага хүлээлгэхээргүй тохиолдолд зөрчлийн талаар мэдүүлэг гаргагчид нь тайлбарлаж, анхааруулах зэрэг арга хэмжээг авч ажиллалаа.

Нарийвчилсан хяналт шалгалтын дүнгээс харахад албан тушаалтнууд өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хамтран өмчилдөг хөрөнгө, орлого болон түүнд орсон их хэмжээний өөрчлөлтийг хуульд заасан хугацаанд мэдүүлээгүй, бусдад худалдсан тээврийн хэрэгслийг худалдан авсан иргэний нэр дээр шилжүүлээгүй, цалингийн орлогыг гарт олгосон дүнгээр мэдүүлэх, эзэмших эрх бүхий газар, гэр бүлийн гишүүдийн хөрөнгө оруулсан компани, хувьцааг мэдүүлээгүй, харилцах данс, картын данс, бэлэн мөнгөний үлдэгдлийг оны эцсийн үлдэгдлээр бус, мэдүүлэг гаргах үеийн байдлаар мэдүүлсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэрийг тайлбарлаагүй зэрэг нийтлэг зөрчлүүд илэрсэн болно.

Хүснэгт 6. Нарийвчилсан хяналт шалгалт хийсэн ХАСХОМ-ийн тоо, оноор

		Нарийвчилсан хяналт шалгалт		
		2013	2014	2015
Нийт шалгасан ХАСХОМ		533	450	552
Хариуцлага тооцсон		110	45	52
Үүнээс:	АЭХ ¹ -ийн 13.8.1-т заасны дагуу “Сануулах”	19	15	22
	АЭХ-ийн 13.8.2-т заасны дагуу “цалингийн хэмжээг бууруулах”	61	24	27
	АЭХ-ийн 13.8.3-т заасны дагуу “албан тушаал бууруулах”	11	1	-
	АЭХ-ийн 13.8.4-т заасны дагуу “огцруулах буюу ажлаас халах”	13	5	3

¹ Авлигын эсрэг хууль

3. Мэдүүлэг гаргагч болон мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудыг чадавхжуулах чиглэлээр

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хугацаанд мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудыг чадавхжуулах, мэдүүлэг гаргагч нарын мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор 2015 онд 122 байгууллагын 884 эрх бүхий албан тушаалтан, 8805 мэдүүлэг гаргагч, 448 удирдах ажилтан, нийт 10137 хүн /давхардсан тоогоор/-ийг хамруулсан сургалтыг зохион байгуулж ажилласан байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Мэдүүлэг гаргагч болон мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудыг чадавхжуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтад оролцогчдын тоо

Д/д	Сургалт	2013	2014	2015
1.	Мэдүүлэг гаргагч	9531	6568	8805
2.	Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтан	1436	2130	884
3.	Удирдах ажилтан	-	-	448
	Нийт	10967	8698	10137


Тайлант хугацаанд “Нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага”-ыг шинэчлэн боловсруулж 20000 ширхэг, урьдчилсан мэдүүлэг, мэдэгдэл, тайлбар, их хэмжээний өөрчлөлт, мэдүүлэг гаргах, хуулийн хугацаа сануулсан 4 төрлийн зурагт хуудсыг 44000 ширхэг, “Эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан гарын авлага” /шинэчилсэн 5 дахь хэвлэл/-ыг шинэчлэн боловсруулж 2350 ширхгийг тус тус хэвлүүлж, нийтэд түгээв.

4. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийн хяналт

Хууль тогтоомжид заасны дагуу Авлигатай тэмцэх газар нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг ажлын 10 өдөрт багтаан хянан үзээд тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх талаар томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж ажиллалаа.


2015 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 8538 этгээдийн ХАСУМ-ийг хүлээн авснаас 8243 этгээдийн ХАСУМ-ийг хянан шийдвэрлэж холбогдох байгууллагад хариу хүргүүлэв. Тус газар нь 2012 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 3106 этгээдийн ХАСУМ-ийг хүлээн авч байсан бол энэ тоо 2013 онд 10338, 2014 онд 13226 болж нэмэгдсэн бөгөөд энэ нь Засгийн газар, яам агентлагийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн зэрэгтэй холбоотой байсан. Харин 2015 оны мэдүүлгийн тоо буурсан нь 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 20 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-д нэмэлт, өөрчлөлт орж, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргах нэр дэвшигчдийн хамрах хүрээ багассантай холбоотой юм (Зураг 5.).

Зураг 5. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийн тоо, оноор




Хянасан 8243 ХАСУМ-ээс 458 нэр дэвшигчийг ашиг сонирхлын зөрчил үүсч болохуйц нөхцөл байдлыг тогтоож, анхааруулсан, 40 нэр дэвшигчийг тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон талаарх дүгнэлтийг холбогдох байгууллагад хүргүүлж ажиллав (Зураг 6).

Зураг 6. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийн шийдвэрлэлт, оноор



Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ийг байршлаар авч үзвэл Улаанбаатар хотод байршилтай байгууллагуудаас 5902 ХАСУМ ирүүлсэн бөгөөд үүний 307 ХАСУМ-ийг ашиг сонирхлын зөрчил үүсч болохуйц нөхцөл байдлыг тогтоож анхааруулсан, 31 ХАСУМ-ийг илт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон талаар томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдсэн болно. Харин Өвөрхангай, Баянхонгор, Дорноговь аймгаас хамгийн олон ХАСУМ-ийг ирүүлсэн бол Говь-Алтай, Дархан-Уул, Өвөрхангай аймгуудаас ирүүлсэн ХАСУМ-ийн дунд ашиг сонирхлын зөрчил үүсч болохуйц нөхцөл байдалтай мэдүүлэг бусад аймгийн дүнгээс олон байв.

Зураг 7. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ, аймгаар



Нийтийн болон төрийн албанд нэр дэвшигчийг томилохдоо Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчих, нэг нутаг, нам, эвсэл, төрийн бус байгууллага зэрэг хүрээллээр томилох хандлага нь “олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц” нөхцөл байдал үүсгэж байгаа тул холбогдох байгууллагуудад тухай бүр зөвлөмж, чиглэл хүргүүлж байв.

Цаашид нийтийн албанд томилогдохоор нэр дэвшигч нь Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан болзол шалгуурыг хэрхэн хангаж байгаа, сонгон шалгаруулалтад орж тэнцсэн, нөөцөд авагдсан эсэх, тухайн ажлын байранд тавигдах, шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх болон төрийн албанаас чөлөөлөгдсөн, халагдсан этгээд дахин өөр албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн байдлыг судлан тогтоох чиглэлээр Төрийн албаны зөвлөл болон Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран ажиллах зайлшгүй шаардлага гарч байна.

5. Их хэмжээний өөрчлөлтөө мэдүүлсэн байдал

Авлигын эсрэг хуулийн дагуу мэдүүлэг гаргагчийн хөрөнгө, орлогод нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол түүнийг тухай бүр 30 хоногийн дотор мэдүүлэх үүрэгтэй байдаг. Улсын хэмжээнд 2015 онд 920 албан тушаалтан хөрөнгө, орлогоддоо их хэмжээний өөрчлөлт орсон талаар мэдүүлсэн байна.

Хүснэгт 8. Их хэмжээний өөрчлөлт мэдүүлсэн байдал, оноор

	2014	2015
Их хэмжээний өөрчлөлт мэдүүлсэн	1648	920

6. Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл тайлбар гаргах


Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах; хэрвээ зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх үүрэгтэй байдаг. 2015 онд ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн тоо 26189, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбар гаргасан тоо 786 болж өмнөх оныхоос нэмэгдсэн дүнтэй байна.

Хүснэгт 9. Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл тайлбар гаргасан байдал, оноор

	2014	2015
Ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн	18225	26189
Ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбар гаргасан	184	786

Ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн болон ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл тайлбар гаргасан байдлыг аймаг, нийслэлээр (Зураг 8.)-д харуулав.

Зураг 8. Ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэл тайлбар гаргасан байдал, аймаг, нийслэлээр



7. Авлига, ашиг сонирхлын зөрчил бүхий өргөдөл, гомдол, мэдээллийн хяналт шалгалтын ажлын талаар


2015 онд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар ирүүлсэн нийт 341 өргөдөл, гомдол, мэдээллийг /цаашид ӨГМ гэх/ хүлээн авснаас тайлант хугацаанд 326 ӨГМ-ийг хянан шийдвэрлэж, оны эцэст 16 ӨГМ үлдэгдэлтэй байна. ӨГМ-ийг агуулгаар нь авч үзвэл хууль бус томилгоотой холбоотой ӨГМ нийт дүнд 23 хувийг эзэлж байна (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Хүлээн авсан авлига, ашиг сонирхлын зөрчил бүхий өргөдөл, гомдол, мэдээлэл

Зөрчлийн шинж чанар	2013	2014	2015
Авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар ирүүлсэн нийт ӨГМ	311	317	341

Авлига, ашиг сонирхлын зөрчил бүхий ӨГМ-ийг агуулгаар нь авч үзвэл ашиг сонирхлын зөрчил болон сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан талаар ирүүлсэн нь нийт дүнгийн 31.0 хувь, хууль бус томилгоотой холбоотой ирүүлсэн нь 23.0 хувь, албаны эрх мэдлээ урвуулсан, хэтрүүлсэнтэй холбоотой ирүүлсэн нь 19.6 хувийг эзэлж байна.

Зураг 9. Авлига, ашиг сонирхлын зөрчил бүхий ӨГМ, агуулгаар



Хянан шийдвэрлэсэн 326 ӨГМ-ийг шийдвэрлэлтийн байдлаар авч үзвэл албан тушаалтны буруутай үйл ажиллагааг илрүүлж, хариуцлага тооцуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд албан бичиг хүргүүлсэн 74 буюу 22.6 хувь (сануулсан-12, цалин бууруулсан 23, албан тушаал бууруулсан 2, огцруулах буюу ажлаас халсан-19) байв. Мөн ӨГМ-ийн шийдвэрлэлтийн хүрээнд 52 удаа зөрчлийг арилгуулахаар зөвлөмж, чиглэл хүргүүлж, 9 удаа авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй тушаал, шийдвэр, захирамжийг хүчингүй болгуулах арга хэмжээг авч ажилласан байна.

Хүснэгт 11. Хянан шийдвэрлэсэн ӨГМ, шийдвэрлэлтээр


Үзүүлэлт		2013	2014	2015
Нийт хянан шийдвэрлэсэн ӨГМ		282	283	326
Хариуцлага тооцуулсан		45	45	74
Үүнээс:	Сануулсан	5	2	12
	Цалин бууруулсан	20	17	23
	Албан тушаал бууруулсан	6	4	2
	Огцруулах буюу ажлаас халах	10	22	19
	Бусад	4	-	15

1.3 ХУУЛИАР ХАРЬЯАЛУУЛСАН ГЭМТ ХЭРЭГТ ЯВУУЛСАН МӨРДӨН БАЙЦААЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

1. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл

Тус газар 2015 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 1027 гомдол, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 428 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь 41.7 хувийг эзэлж байна. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 70-аар буюу 14.0 хувиар буурсан байна. Шинээр хүлээн авсан 428 гомдол, мэдээллээс гадна өмнөх оны үлдэгдэл 12, нийт 440 гомдол, мэдээллийг хянан үзсэн байна (Зураг 10).


Зураг 10. Хянан үзсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн тоо оноор



Хянан үзсэн гомдол, мэдээллээс 92 гомдол, мэдээлэл буюу 20.9 хувьд эрүүгийн хэрэг үүсгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 3.7 хувиар өссөн, 265 гомдол, мэдээлэл буюу 60.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан нь өмнөх оны мөн үеийнхээс 2.3 хувиар буурсан, 70 гомдол, мэдээлэл буюу 15.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1.5 хувиар буурсан бөгөөд шийдвэрлэлт 97.1 хувьтай, ажиллагаанд 13 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй байна (Зураг 11).

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг агуулга, холбогдох байгууллага, салбараар нь авч үзвэл нийтийн алба, төрийн албаны үйл ажиллагаанд хамаарах 375 гомдол, мэдээллээс төрийн улс төрийн албанд хамаарах 88, төрийн захиргааны албанд хамаарах 169, төрийн тусгай албанд хамаарах 61, төрийн үйлчилгээний албанд хамаарах 57 гомдол, мэдээлэл, бусад салбарт хамаарах 65 гомдол, мэдээллээс хувийн хэвшлийн үйл ажиллагаанд хамаарах 33, улс төрийн намын үйл ажиллагаанд хамаарах 2, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 10, бусад 20 гомдол, мэдээлэл шалгагдсан болно.

Зураг 11. Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт, оноор




2015 онд тус байгууллагад албан бичгээр 192, шуудангаар 85, цахим шуудан, вэб сайтаар 8, биечлэн 147, утсаар 6, факсаар 2 гомдол, мэдээлэл ирүүлжээ.

Нийт шалгасан гомдол, мэдээллийн 277 буюу 62.9 хувь нь Улаанбаатар хотын, 163 буюу 37.1 хувь нь орон нутгийн харьяалалтай байна.

2. Мөрдөн байцаалт явуулсан хэрэг, шийдвэрлэлт

2015 онд хуульд заасан харьяаллын 345 үйлдэл, 410 холбогдогчтой 238 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байна (Зураг 12).


Зураг 12. Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийн тоо, оноор



Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 238 эрүүгийн хэргээс 55 хэргийг буюу 23.1 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр, 50 хэргийг буюу 21.0 хувийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар, 30 хэргийг буюу 12.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, 28 хэргийг буюу 11.8 хувийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэж, 13 хэргийн мөрдөн байцаалтын

ажиллагааг түдгэлзүүлж тус тус шийдвэрлэжээ. 2015 оны эцэст 62 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байна (Зураг 13).


Зураг 13. Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийн шийдвэрлэлт, тоогоор



Яллах дүгнэлт үйлдүүлэхээр 2015 онд прокурорт шилжүүлсэн эрүүгийн 55 дугаартай хэргийг Эрүүгийн хуулийн зүйлчлэлээр авч үзвэл хээл хахууль өгөх 29, хээл хахууль авах 28, төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах 25, төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 11, хээл хахууль зуучлах 8 байв.

Эрүүгийн хэрэгт холбогдон 410 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.4 хувиар буурсан байна. Хэргийн холбогдогчдыг албан тушаалын байдлаар нь авч үзвэл төрийн албан тушаалтан 223 буюу 54.4 хувь (төрийн улс төрийн 42, төрийн захиргааны 79, төрийн тусгай 44, төрийн үйлчилгээний 58), төрийн бус байгууллагын болон бусад албан тушаалтан 187 буюу 45.6 хувийг эзэлж байна (Зураг 14).


Зураг 14. Эрүүгийн хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдсан нийт хүний тоо, албан тушаалын байдлаар



Яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн хэргээс 2015 онд ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Н.Түмэндэмбэрэл, ОБЕГ-ын Гал түймэртэй


тэмцэх газарт тасгийн даргаар ажиллаж байсан Д.Тогооням, ИХШХЕГ-ын хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Ж.Пунцаг, Увс аймгийн Өмнөговь сумын сургуулийн захирал Б.Лхамсүрэн, Налайх дүүргийн Цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаагч М.Гансүлд, Ерөнхий сайдын ахлах зөвлөх асан Л.Гансүх, Цэвэр агаар сангийн захирал Н.Хүрэлсүх, ня-бо М.Хулан нарын 68 хүнд холбогдох 24 эрүүгийн хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн байна (Зураг 15).

Зураг 15. Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо, оноор



Гэмт хэргийн улмаас 50.3 тэрбум төгрөгийн хохирол учирснаас мөрдөн байцаалтын шатанд 2.9 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн, 11.6 тэрбум төгрөгийн эд зүйлийг битүүмжлэн хамгаалсан, 800.5 сая төгрөгийн нуугдмал мөнгө, эд хөрөнгө илрүүлсэн дүнтэй ажилласан байна.


Зураг 16. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн, битүүмжилсэн хэмжээ, оноор, тэрбум төгрөг



Гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирлоос мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн хэмжээ 2015 онд нийт хохирлын дүнгийн 5.8 хувь байгаа бол эд зүйлийг битүүмжлэн хамгаалсан хэмжээ нийт хохирлын дүнгийн

23.1 хувьтай тэнцэж байна. 2014 онд мөрдөн байцаалтын шатанд нийт хохирлын 28.5 хувьтай тэнцэх хэмжээний буюу 17.4 тэрбум төгрөгийн эд зүйлийг битүүмжлэн хамгаалсан (Зураг 17).

Зураг 17. Учирсан хохирлын дүнд мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн, битүүмжилсэн хувь, оноор




Шүүхээс 8 847 242 855 төгрөгийг улсын орлого болгох шийдвэр гарсан дүнтэй байна.

3. Мөрдөн байцаалт явуулсан хэргийн шийдвэрлэлт, аймаг, нийслэлээр

Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийг аймаг, нийслэлээр авч үзвэл 2015 онд нийслэл Улаанбаатар хотод 161 хэрэг буюу нийт хэргийн 67.6 хувь нь, аймгуудад 77 хэрэг буюу 32.4 хувь нь үйлдэгджээ (Зураг 18).

Зураг 18. Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийн хувийн жин, аймаг, нийслэлээр




Улаанбаатар хотод мөрдөн байцаалт явуулсан 161 хэргээс 30 хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтай прокурорт шилжүүлж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад 42.5 тэрбум төгрөгийн хохирол учирснаас мөрдөн байцаалтын шатанд 2.2 тэрбум төгрөгийг нөхөн төлүүлж, 7.6 тэрбум төгрөгийн эд зүйлийг битүүмжлэн хамгаалсан байна.

Хөдөө орон нутагт үйлдэгдсэн 77 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас 25 хэрэг буюу 32.4 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлсэн байна.

2015 онд мөрдөн байцаалт явуулсан хэргийн тоогоор авч үзвэл Дархан-Уул аймагт 11, Сэлэнгэ 7, Ховд 6, Орхон 5, Дорнод, Дундговь, Өмнөговь, Төв аймагт тус бүр 4, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Сүхбаатар, Увс, Хөвсгөл аймагт тус бүр 3 байна (Зураг 19).


Зураг 19. Мөрдөн байцаалт явуулсан хэргийн шийдвэрлэлт, аймаг, нийслэлээр



2015 онд аймаг, орон нутагт мөрдөн байцаалт явуулсан хэргүүдээс яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлсэн хэргийн тоог аймаг тус бүрээр авч үзвэл Сэлэнгэ аймагт 4, Баянхонгор аймагт 3, Хөвсгөл, Дундговь, Ховд, Дархан-Уул аймагт тус бүр 2, Булган, Завхан, Өвөрхангай, Архангай, Баян-Өлгий, Сүхбаатар, Говьсүмбэр, Дорнод, Өмнөговь, Төв аймагт тус бүр 1 хэрэг байлаа.

Гэмт хэргийн улмаас 2015 онд аймагт 7.8 тэрбум төгрөгийн хохирол иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан бөгөөд аймаг тус бүрээр (Зураг 20.)-д харуулав.

Зураг 20. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, сая төгрөг



2015 онд эрүүгийн хэрэгт холбогдсон 410 этгээдээс 28 буюу 6.8 хувьд нь цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан байна.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН АВЛИГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс дахь авлигын нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор дотоодын болон олон улсын байгууллагууд олон тооны судалгааг 2015 онд зохион байгуулсан байна. Уг судалгаануудын үр дүнд үндэслэн Монгол Улсын авлигын ерөнхий нөхцөл байдлыг танилцуулж байна.

2.1 АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКС²

Олон улсын хэмжээнд дэлхийн улс орнуудын авлигын түвшин хэрхэн өөрчлөгдөж байгааг харьцуулан үнэлгээ гаргадаг “Транспарэнси Интернэшнл” байгууллагын Авлигын төсөөллийн индекс (АТИ)-ийг 1995-2011 оны хооронд 0-10 хүртэл оноогоор үнэлдэг байсныг 2012 оноос эхлэн 0 (авлигад автсан), 100 (авлигагүй) хүртэл оноогоор үнэлдэг болсон юм. Авлигын төсөөллийн индексийн судалгааны аргачлал ийнхүү 2012 онд өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2012, 2013, 2014 оны судалгааны дүнг харьцуулахуйц боломж бүрдсэн бөгөөд 2015 оны судалгаагаар манай улс 39 оноо авч судалгаанд хамрагдсан 168 орноос 72 дугаар байрт ороод байна. Судалгааны үр дүнг 2012 оныхтой харьцуулахад АТИ-ийн утга 3 пунктээр нэмэгдэж, эзлэх байр 22-оор ахисан, 2013 оныхтой харьцуулахад АТИ-ийн утга 1 пунктээр нэмэгдэж, эзлэх байр 11-ээр ахисан, 2014 оныхтой харьцуулахад АТИ-ийн утга өөрчлөгдөөгүй ч эзлэх байр 8-аар ахисан эерэг үзүүлэлттэй байна. (Хүснэгт 12).

Хүснэгт 12. Авлигын төсөөллийн индексийн утга болон үнэлгээнд хамрагдсан улс орнууд дунд эзлэх байр

	2008	2009	2010	2011	2012 ³	2013	2014	2015
Авлигын төсөөллийн индексийн утга	3.0	2.7	2.7	2.7	36	38	39	39
Монгол Улсын эзэлж буй байр	102	120	116	120	94	83	80	72
Үнэлгээнд хамрагдсан улс орны тоо	180	180	178	182	176	177	175	168

Монгол Улсыг үнэлсэн үзүүлэлтийн дүнг 2015 оны оноог 2014 онтой харьцуулан харахад "Бертелсман" сан-Шилжилтийн индекс 2016 үнэлгээгээр оноо буурсан байна.

Авлигын төсөөллийн индекс нь 168 орны төрийн албан дахь авлигын төсөөллийн дүнг харуулдаг. Дани Улс сүүлийн 2 жилд хамгийн өндөр оноо авч хамгийн авлигагүй цэвэр оноор тодорч тэргүүлж байгаа бол Хойд Солонгос ба Сомали Улс 8 оноо авч баян ходоод болжээ. Тэргүүлж буй орнуудад дараахь нийтлэг шинжүүд илэрч байна. Хэвлэлийн эрх чөлөө, төсвийн зарцуулалтад тавих иргэдийн хяналт хүчтэй, шүүх засаглал нь шударга, баян ба ядуу хүмүүст тэгш хандах, төрийн бусад байгууллагаасаа


² <http://www.transparency.org/cpi2015/results> (хандалт 2016 оны 3 дугаар сарын 10-ний өдөр)

³ 2012 оноос эхлэн үзүүлэлтийг 0-100 оноогоор дүгнэдэг болсон бөгөөд индексийн утга 100-д дөхөх тусам авлигагүй, 0-д дөхөх тусам авлигад автсан байгааг илэрхийлнэ.

хараат бус байдал зэрэг орж байна. Хамгийн доод оноо авсан улс орнуудад ажиглагдаж буй нийтлэг шинж нь дайн тулаантай, засаглал нь сул, цагдаа ба шүүх засаглал нь сул, хараат байдал, хэвлэлийн эрх чөлөө сул зэрэг шинж ажиглагдаж байна.

Харин манай хөрш ОХУ-ын хувьд өмнөх оноос оноо 2-оор нэмэгдэж 29 оноо 119-р байр, БНХАУ-ын хувьд өмнөх оноос оноо 1-ээр нэмэгдэж 37 оноо болж 83-р байрт тус тус орсон байна.

Зураг 21. Авлигын төсөөллийн индекс-2015, улсаар⁴



Авлигын төсөөллийн индексийг төрийн албан дахь авлигыг дүгнэсэн шинжээчдийн үнэлгээнд үндэслэн гаргадаг. Улс орнуудын авч буй өндөр оноо нь нээлттэй ил тод засаглал болон эрх баригчдын иргэдийн өмнө хүлээх хариуцлагын тогтолцоотой шууд холбоотой байдаг байна. Харин бага оноо авсан улс орнуудад авлига их, авлигын хэрэг ял шийтгэлгүй өнгөрдөг, шүүх цагдаа нь шударга бус зэрэг нийтлэг шинжтэй байдаг байна.

2.2 ХӨГЖИЖ БУЙ УЛС ОРНУУДААС ГАДАГШ ШИЛЖСЭН ХУУЛЬ БУС САНХҮҮГИЙН УРСГАЛ

Дэлхийн санхүүгийн шударга байдал⁵ байгууллагаас хөгжиж буй улс орнуудаас гадагш шилжсэн хууль бус санхүүгийн урсгал⁶-ын хэмжээг тооцон 2015 оны 12 дугаар сард 7 дахь удаагийн тайлангаа гаргав. Уг тайланд дурдсанаар сүүлийн 10 жилийн хугацаанд буюу 2004-2013 оны хооронд хөгжиж буй улс орнуудаас нийтдээ 7.8 их наяд ам.доллартай тэнцэх хэмжээний хөрөнгө гадагш шилжсэн байна. Зөвхөн 2013 оны

⁴ улаан өнгөөр авлигатай, шар өнгөөр авлига багатай улсыг тэмдэглэв

⁵ Global financial integrity

⁶ Illicit financial flow from Developing countries

байдлаар гадагш шилжсэн хууль бус санхүүгийн урсгалын хэмжээ анх удаагаа 1.1 их наяд ам. доллар болж нэмэгдсэн байгааг онцолсон байна. Уг тайланд Монгол Улсаас гадагш шилжсэн хууль бус санхүүгийн урсгалын хэмжээ 2004-2013 оны хооронд нийтдээ 1.5 тэрбум ам. доллар байв (Хүснэгт 13).

Хүснэгт 13. Хөгжиж буй улс орнуудаас гадагш шилжсэн хууль бус санхүүгийн урсгалын хэмжээ, 2003-2012 онд, сая ам. доллар

Он	Монгол	ОХУ	БНХАУ	Ази	Хөгжиж буй улс орнуудын дүн
2004	0	47,136	80,370	167,059	380,835
2005	81	57,502	82,313	184,743	488,997
2006	14	66,825	87,520	201,288	502,809
2007	212	82,069	107,075	227,275	593,472
2008	774	103,972	104,854	263,351	793,435
2009	0	129,459	139,911	267,337	748,307
2010	0	135,033	173,626	368,086	821,939
2011	76	187,695	162,779	371,426	968,684
2012	195	122,864	249,567	456,709	991,245
2013	125	120,331	258,640	481,988	1,090,130
ДҮН	1,478	1,049,772	1,392,276	3,048,278	7,847,921
Жилийн дундаж	148	104,977	139,228	304,828	784,792

Эх сурвалж: Дэлхийн санхүүгийн шударга байдал байгууллага, <http://www.gfintegrity.org/report/illicit-financial-flows-from-developing-countries-2004-2013/>

2.3 ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁСНЫ ИНДЕКС⁷

“Дэлхийн хууль дээдлэх ёсны төсөл” ашгийн бус, бие даасан байгууллага бөгөөд дэлхийн улс орнуудад хууль ёсыг дээдлэн сахиж буй байдлыг судалгаанд үндэслэн үнэлдэг.

Өнгөрсөн оны судалгаанд дэлхийн 102 орныг хамруулснаас Монгол Улс 0.53 оноотойгоор 47 дүгээр байранд орсон бөгөөд өмнөх оныхоос 0.02-оор оноо нэмэгдэж, эзлэх байр 4-өөр ахисан эерэг үзүүлэлттэй байна.

Хууль дээдлэх ёсны 2014 оны индексээр Дани (0.87), Норвеги (0.87), Швед (0.85), Финланд (0.85), Нидерланд (0.83), Шинэ Зеланд (0.83) зэрэг улсууд эхний байруудад орсон бол Венесуэл (0.32), Афганистан (0.35), Зимбабве (0.37), Пакистан (0.38), Камерун (0.40), Болив (0.41), Бангладеш (0.42) улсууд сүүлийн байруудад жагсжээ. Монгол Улс 0.53 оноотой байгаа нь Балба, Панам, Беларусь, Филиппин улсуудтай адил байгаа бөгөөд индексийн хүчин зүйл тус бүрээр авч үзвэл (үндсэн 8 хүчин зүйлийг харгалзан үздэг):

Хүснэгт 14. Хууль дээдлэх ёсны индексийн дэд үзүүлэлтээр, Монгол Улс

Үзүүлэлт	2014	2015
Хууль дээдлэх ёсны индекс	0.51	0.53
-авлигаас ангид байдал	0.39	0.42
-дэг журам, аюулгүй байдал	0.78	0.79
-суурь эрх, эрх чөлөө	0.61	0.61

⁷Дэлхийн хууль дээдлэх ёсны төсөл, <http://worldjusticeproject.org/>, (Хандалт 2016 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр)

-засгийн газрын эрх мэдлийн хязгаарлалт	0.53	0.54
-иргэний хэрэг хянан шийдвэрлэж буй байдал	0.52	0.55
-эрүүгийн хэрэг шийдвэрлэж буй байдал	0.48	0.42
-хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа	0.43	0.48
-нээлттэй засаг	0.33	0.46

Монгол Улс дахь **авлигаас ангид байдлын үзүүлэлттэй** холбоотой асуултад хариулснаас үзвэл шүүх засаглал нь авлигаас ангид гэж 52 хувь, цагдаа, армийн салбар нь авлигаас ангид гэж 55 хувь нь, хууль тогтоох засаглал нь авлигаас ангид гэж 16 хувь нь, гүйцэтгэх засаглал нь авлигаас ангид гэж 45 хувь нь үзжээ.

2.4 МӨНГӨ УГААХЫН ЭСРЭГ ИНДЕКС

Базелийн Засаглалын хүрээлэнгээс зохион байгуулан гаргадаг “Мөнгө угаахын эсрэг индекс” судалгаагаар Монгол Улс 2015 онд 6.13 гэсэн үнэлгээ авсан байна (Хүснэгт 15). “Мөнгө угаахын эсрэг индекс” судалгаа нь улс орнуудын мөнгө угаах болон алан хядах үйл ажиллагааг санхүүжүүлэх эрсдлийг үнэлдэг юм. Базелийн Засаглалын хүрээлэн энэхүү үнэлгээг Транспарэнси интернэшнл, Дэлхийн банк, Дэлхийн эдийн засгийн форум зэрэг 14 байгууллагын мэдээлэлд үндэслэн гаргадаг байна. Үнэлгээ нь 0 (эрсдэл бага) –ээс 10 (эрсдэл их) гэсэн байдлаар гаргадаг. Мөнгө угаах эрсдлийг улс төрийн болон эрх зүйн эрсдэл, олон нийтийн ил тод байдал, хариуцлагатай байдлын эрсдэл, санхүүгийн ил тод, тунгалаг байдлын стандартууд, авлигын эрсдэл болон мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэх эрсдэл зэрэг үзүүлэлтүүдээр авч үздэг юм.

Дэлхийн хэмжээнд мөнгө угаах эрсдэл өндөртэй улс орнуудад Иран (8.59), Афганистан (8.48), Тажикстан (8.26), Гвиней-Бисау (8.15), Мали (7.97), Камбож (7.93), Мозамбик (7.90), байгаа бол мөнгө угаах, олон улсын алан хядах ажиллагаа санхүүжүүлэх эрсдэл багатай орнуудад Финлянд (2.53), Эстон (3.19), Словени (3.41), Литв (3.67), Шинэ Зеланд (3.78), Болгар (3.79), Польш (3.99) улс багтжээ.

“Мөнгө угаахын эсрэг индекс” судалгаагаар Монгол Улс 2015 онд 6.13 гэсэн үнэлгээ авсан нь судалгаанд хамрагдсан 152 улсаас 61 дүгээр байрт эрэмбэлэгдсэн байна.

Хүснэгт 15. Монгол Улсын Мөнгө угаахын эсрэг индексийн үзүүлэлт, оноор

Улс	2012	2013	2014	2015
Монгол Улс	6.35	6.14	6.14	6.13

2.5 ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-т заасны дагуу “авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жилд нэгээс доошгүй удаа судлан авлигын индексийг гаргаж олон нийтэд мэдээлэх”; мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7-д заасны дагуу “төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх” чиг үүргийг тус тус хэрэгжүүлдэг. Уг чиг үүргийн хүрээнд төрийн байгууллагын Шударга байдлын үнэлгээг гаргаад байна.

Шударга байдлын үнэлгээ (ШБҮ) гэж тухайн байгууллагын гадаад шударга байдлын үнэлгээ, дотоод шударга байдлын үнэлгээ, бодлогод оролцогчдын үнэлгээнд үндэслэсэн нийт үнэлгээнээс бүрдэнэ. Үүнд:

- **Гадаад ШБҮ** гэж тухайн байгууллагын шударга байдалд үйлчилгээ авсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллийн өгч буй үнэлгээг;
- **Дотоод ШБҮ** гэж тухайн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын зүгээс байгууллагынхаа талаар өгч буй үнэлгээг;
- **Бодлогод оролцогчдын үнэлгээ** гэж тухайн байгууллагын шударга байдлын талаарх бодлого боловсруулах, төлөвлөх үе шатанд оролцогчдын өгсөн үнэлгээг хэлдэг;

Шударга байдлын үнэлгээг 0-100 хүртэл оноогоор гаргах бөгөөд үнэлгээний утга 100-тай тэнцүү бол хамгийн шударгыг илэрхийлнэ. ШБҮ-2015-д 62 төрийн байгууллага (яам, засгийн газрын агентлаг, аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар)-ыг хамруулсан.

Төрийн байгууллагуудын ШБҮ 2015 оны байдлаар 100 оноо авахаас 73.8 байв. ШБҮ-ний дүнгээс харахад байгууллагын дотоод ШБҮ-ний оноо 81.9 гарсан байгаа бол гадаад ШБҮ болон бодлогод оролцогчдын үнэлгээний оноо тус бүр 69.8 гэсэн дүнтэй гарсан байна.

Хүснэгт 16. Төрийн байгууллагын ШБҮ, дэд үзүүлэлтээр

Үзүүлэлт	Үнэлгээ
ШБҮ	73.8
1. Гадаад шударга байдлын үнэлгээ	69.8
- Авлигын эрсдлийн индекс	61.2
- Авлигын индекс	78.5
2. Дотоод шударга байдлын үнэлгээ	81.9
- Соёлын индекс	74.4
- Ажлын байран дахь шударга байдлын индекс	89.4
3. Бодлогод оролцогчдын үнэлгээ	69.8

Байгууллагын төрлөөр нь авч үзвэл яамдын ШБҮ-ний дундаж оноо 72.4 гарсан бөгөөд үүнээс, Барилга, хот байгуулалтын яамны ШБҮ-ний оноо 65.8, Эрүүл мэнд, спортын яамны ШБҮ-ний оноо 66.1, Зам тээврийн яамны ШБҮ-ний оноо 69.0, Байгаль, орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны ШБҮ-ний оноо 69.3 гарсан нь оноо багатай яам болж байна.

Харин Засгийн газрын агентлагийн хувьд ШБҮ-ний дундаж оноо 75.5 гарсан бөгөөд Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (67.3), Ашигт малтмалын газар (68.2), Гаалийн ерөнхий газар (68.9), Татварын ерөнхий газар (69.2) үнэлгээгээр доогуур оноотой гарсан байна.

Мөн аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ШБҮ-ний дундаж оноо 72.9 байгаа бөгөөд Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар (65.5), Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар (66.2), Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар (66.6), Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар (67.6) бага оноотой байгууллага болж байна (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Шударга байдлын үнэлгээ-2015, байгууллагаар

Яам	Үнэлгээ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	Үнэлгээ
Барилга, хот байгуулалтын яам	65.8	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	78.5
Эрүүл мэнд, спортын яам	66.1	Хөвсгөл аймгийн ЗДТГ	79.0
Зам тээврийн яам	69.0	Увс аймгийн ЗДТГ	79.4
Байгаль, орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яам	69.3	Дорноговь аймгийн ЗДТГ	81.3
Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам	70.0	ЗГ-ын агентлаг	Үнэлгээ
Уул уурхайн яам	71.3	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	67.3
Хүнс, хөдөө аж ахуйн яам	71.4	Ашигт малтмалын газар	68.2
Хууль зүйн яам	72.2	Гаалийн ерөнхий газар	68.9
Аж үйлдвэрийн яам	72.6	Татварын ерөнхий газар	69.2
Хөдөлмөрийн яам	73.5	Иргэний нисэхийн ерөнхий газар	72.3
Эрчим хүчний яам	75.4	Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар	73.1
Сангийн яам	75.6	Мал эмнэлэг, үржлийн газар	73.4
Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	77.2	Улсын бүртгэлийн ерөнхий газар	73.7
Гадаад хэргийн яам	77.2	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	73.9
Батлан хамгаалах яам	78.9	Архивын ерөнхий газар	75.3
Аймаг, нийслэлийн ЗДТГ	Үнэлгээ	Хүүхдийн төлөө үндэсний газар	75.7
Баян-Өлгий аймгийн ЗДТГ	65.5	Хөрөнгө оруулалтын газар	76.4
Завхан аймгийн ЗДТГ	66.2	Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар	76.9
Дундговь аймгийн ЗДТГ	66.6	Цагдаагийн ерөнхий газар	77.1
Өмнөговь аймгийн ЗДТГ	67.6	Худалдан авах ажиллагааны газар	77.3
Хэнтий аймгийн ЗДТГ	70.8	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар	77.5
Дархан-Уул аймгийн ЗДТГ	70.9	Газрын тосны газар	77.6
Төв аймгийн ЗДТГ	71.3	Онцгой байдлын ерөнхий газар	77.8
Ховд аймгийн ЗДТГ	71.3	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	78.1
Дорнод аймгийн ЗДТГ	71.3	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар	79.0
Орхон аймгийн ЗДТГ	72.2	Стандартчилал, хэмжил зүйн газар	79.2
Архангай аймгийн ЗДТГ	72.2	Тахарын ерөнхий газар	79.3
Өвөрхангай аймгийн ЗДТГ	72.6	Оюуны өмчийн газар	79.4
Нийслэлийн ЗДТГ	72.8	Нийгмийн даатгалын ерөнхий газар	79.7
Баянхонгор аймгийн ЗДТГ	73.0	Цаг уур, орчны шинжилгээний газар	81.4
Сэлэнгэ аймгийн ЗДТГ	73.6	ШБҮ	73.8
Булган аймгийн ЗДТГ	75.3	Яамдын дундаж	72.4
Говь-Алтай аймгийн ЗДТГ	76.3	ЗГ-ын агентлагийн дундаж	75.5
Сүхбаатар аймгийн ЗДТГ	77.1	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дундаж	71.5

ШБҮ-ний судалгаанд нийтдээ 4340 нэгжийг хамруулсан бөгөөд үүнээс гадаад ШБҮ-нд 2330 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл, дотоод ШБҮ-нд 1390 төрийн албан хаагч, бодлогод оролцогчдын үнэлгээнд 620 шинжээчийг хамруулсан болно. Судалгаанд оролцогчдоос “Монгол Улсад авлига хамгийн их тархсан институц аль нь вэ?” гэж асуухад 46.9 хувь нь эрүүл мэндийн байгууллага, 40.0 хувь нь газрын алба, 36.8 хувь нь шүүх болон гаалийн байгууллага, 31.5 хувь нь мэргэжлийн хяналтын байгууллага, 31.4 хувь нь цагдаагийн байгууллага гэж хариулсан байна (Хүснэгт 18).

Хүснэгт 18. Монгол Улсад авлига хамгийн их тархсан институц аль нь вэ?, хувиар

	Төрийн байгууллагаар үйлчлүүлэгч	Төрийн албан хаагч	Бодлогод оролцогч	Бүгд
Эрүүл мэндийн байгууллага	47.9	46.3	44.9	46.9
Газрын алба	38.8	39.9	44.4	40.0
Шүүх	36.8	37.1	36.0	36.8
Гаалийн байгууллага	32.9	41.0	42.0	36.8
Мэргэжлийн хяналтын байгууллага	28.6	32.2	40.1	31.5
Цагдаагийн байгууллага	34.8	26.4	29.9	31.4
Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	28.5	21.2	35.2	27.2
Боловсролын байгууллага	25.4	23.4	24.6	24.7
Татварын байгууллага	20.2	26.8	31.9	24.0
Улс төрийн нам	16.5	19.2	33.3	19.8
Прокурорын байгууллага	17.6	16.7	16.4	17.1
Нутгийн захиргааны байгууллага	16.6	14.3	20.5	16.4
Хэвлэл мэдээллийн байгууллага	7.3	11.2	12.8	9.4
Хувийн хэвшил	5.4	4.6	3.0	4.8
Төрийн бус байгууллага	4.8	3.2	2.1	3.9
Бусад	2.9	3.3	2.5	3.0
Дүн	100.0	100.0	100.0	100.0


2.6 ХҮҮХДИЙН ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА

Хүүхдийн шударга байдлын түвшинг тодорхойлох, улмаар хүүхдүүдийг шударга иргэн болгон төлөвшүүлэхийн тулд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ, шударга бус хандлагаас нь урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын чиглэлийг тогтоох зорилгоор Хүүхдийн шударга байдлын судалгааг тус газраас жил бүр зохион байгуулан явуулж байна.

Судалгааны мэдээлэлд үндэслэн Хүүхдийн шударга байдлын түвшинг 4 дэд үзүүлэлт (түвшинг ёс зүй, ёс суртахуун, зөв төлөвшилт, хууль сахих, авлигыг үл тэвчих)-ийн хүрээнд 1-5 хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд үзүүлэлтийн утга 1-д ойртох тусам шударга бус, 5-д ойртох тусам шударга гэж ойлгоно.

Уг судалгааны 2015 оны дүнгээр шударга байдлын түвшин авбал зохих 5 онооноос 3.99 оноо авч 2014 оноос 0.04 пунктээр буурсан боловч 2013 оноос 0.28 пунктээр, 2012 оноос 1.06 пунктээр тус тус өссөн дүнтэй байна.

Зураг 22. Хүүхдийн шударга байдлын түвшин, оноор



Судалгааны дүнгээс харахад шударга бус явдалтай санал нийлж байгаа болон зөв шийдвэр гаргахдаа эргэлзэж байгаа хүүхдүүдийн хувийн жин буурахгүй байгаа нь шударга, зарчимч, үнэт зүйлсийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, зөв үзлийг төлөвшүүлэх, шударга байхын ач холбогдлыг таниулах чиглэлийн үйл ажиллагаа дутмаг байгааг илэрхийлж байгаа болно.

Авлигатай тэмцэх газар

